



The AMERICAN CHAMBER of Commerce in Mongolia

Хэвлэлийн мэдээ:

24.09.2019

Холбоо барих:

+976 9511 7771

АмЧам Монгол өөрчлөлт шинэчлэлийн хөдөлгөх хүч болох манлайлагч эмэгтэйчүүдийг дэмжиж ажиллана

УЛААНБААТАР, Монгол улс – Америкийн худалдааны танхим (АмЧам Монгол) 9-р сарын бизнес уулзалтаа "Өөрчлөлтийн хөдөлгөх хүч - эмэгтэй манлайлагчид" гэсэн сэдвээр 2019 оны 9-р сарын 24-ны Мягмар гарагт Blue Sky зочид буудалд зохион байгууллаа.

Монгол эмэгтэйчүүд хэдий өндөр боловсрол эзэмшсэн байдаг ч ажлын байранд бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байна гэсэн дүгнэлтийг Дэлхийн банкны судалгааны үр дүн харуулжээ. Өнөөдөр Монголын бизнес болон улс төрийн хүрээнд өндөр албан тушаалтны 15%-ийг л эмэгтэйчүүд бүрдүүлж байна. АмЧамын энэ удаагийн уулзалтаар Монгол улсад жендэрийн эрх тэгш байдал, хүйсээр ялгаварлан гадуурхах үзэгдэл, эрэгтэй, эмэгтэй ажиллагсдын цалингийн ялгаатай байдал, эмэгтэй манлайлагчдын амжилтын түүх зэрэг асуудлаар урилгаар оролцсон илтгэгч нар өөрсдийн санал бодлоо хуваалцаж сонирхолтой хэлэлцүүлэг өрнүүллээ. Уулзалтад АмЧам Монголын гишүүн компаниуд, хөрөнгө оруулагчид, олон улсын банк, санхүүгийн байгууллагын болон Монгол дахь элчин сайдын яамдын төлөөлөгчид оролцож сонирхсон асуултандаа хариулт авлаа.

Хэлэлцүүлгийг АмЧам Монголын ТУЗ-ийн гишүүн, Монполимет Группын ТУЗ-ийн дарга Н.Мөнхнасан чиглүүлж Монгол дахь жендэрийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийн улс төрийн төлөөллийн асуудал, эрх мэдлийн хуваарилалт, хүртээмжийн ялгаатай байдал, ажил мэргэжил, карьерийг хувийн амьдрал, ээжийн үүрэг болон ар гэрийн амьдралтай хэрхэн хослуулж амжилтанд хүрэх зэрэг сэдвүүдээр уригдсан панелистуудтай ярилцлаа.

ME MGL Advocates хуулийн фирмийн партнер Б.Дуннаран Монгол улсын төрийн бодлого, эдийн засгийн хүрээнд буй жендэрийн ялгаатай байдлыг онцолж яриу. Тухайлбал, ижил хөдөлмөр эрхэлж адил цалин хөлс авах, сурч боловсрох тэгш эрх, өмч эзэмших эрх зэрэг асуудлыг хууль, бодлогоор дэмжих нь чухал гэв.

Монгол ТВ-ийн Ерөнхий захирал Ч. Номин Монголын нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон ялгааг онцлон ярилаа. Бага наснаас нь бид эмэгтэй хүүхдийг даруухан, намуухан байхыг зааж өгдөг бол, эрэгтэй хүүхдийг шийдэмгий, эзэрхэг байхыг зааж өгдөг гэх мэт хүмүүжлийн ялгаатай байдал тод байдгийг онцлов.

Америкийн Монгол судлалын төвийн гүйцэтгэх захирал Патришиа Төрболд хэлэхдээ, "Эмэгтэйчүүд бид хоороондоо өрсөлдөх биш, харин бие биенээ дэмжиж хамтран ажиллаж нэгдмэл байх хэрэгтэй" гэв.

Петровис Вентур Капиталын гүйцэтгэх захирал Б.Шинэзаяа онцлохдоо, "Жендэрийн ойлголт, үзэл, хандлагыг өөрчлөхийн тулд бизнес, хувийн хэвшлийн хүрээнд нэгдэж өнөөдрийн АмЧам Монголын уулзалт шиг нээлттэй ярилцаж байх нь энэхүү өөрчлөлтийн эхний алхам" гэв.

Оролцогчид панелистуудаас асуулт асууж уулзалт үргэлжлэв. Тухайлбал, Bloomberg TV-ийн гүйцэтгэх захирал Э. Долгион "Өнөөдөр яригдаж буй Үндсэн хуулийн өөрчлөлтөд Монгол Улсын Ерөнхийлөгч 55 наснаас дээш байх ёстой гэж санал гаргаж байгаа нь нөгөө талаас эмэгтэйчүүд 55 насандаа тэтгэвэрт гарах сонголттой байдаг хуулийн заалттай харьцуулж тунгаан бодох нь чухал алхам байх болов уу" гэж асууж сонирхолтой хэлэлцүүлгийг өрнүүллээ.

АмЧамын Монголын тухай

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.